

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалын код 03.080.30.

Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Үс засах үйлчилгээнд тавих шаардлага. MNS 5160:2019.	
Service for consumers Requirements barber service	

Нийтлэг үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны 2019 оны дүгээр сарын-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, СХЗГ-ын даргын ... оны ... дүгээр сарын ... тоот тушаалаар батлав.

Энэхүү стандарт 2020 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Өмнөх үг

Хүний үс нь биологийн нэгэн бүтээгдэхүүн бөгөөд гоо сайхны нэгэн хэмжүүр болдог, урган төлждөг байнгын арчилгаа шаарддаг эрхтэн бөгөөд энэхүү гоо сайхны хэмжүүрийг хангахын тулд мэс, химийн бодис, цахилгаан багаж зэргийг ашиглан тухайн хүний толгой, нүүрний хэлбэрт тохируулан засах үйлчилгээ үзүүлдэг.

Энэхүү үйлчилгээ нь ариун цэврийн нөхцлийг хангах ба үйлчилгээ үзүүлэгч этгээдээс мэргэжлийн ур чадварыг шаарддаг үйлчилгээ болно.

Стандартын зорилго нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байгууламж, ариун цэврийн шаардлага хангасан мэргэшсэн үсчнээр үс засах үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлагыг тогтооно.

Үс, хуйхны бүтцийг оношлох, арчлах, эмчлэх, эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн үс засах, химийн аргаар будах /өнгө өөрчлөх/, буржийлгах, шулуутгах, химийн бус аргаар хэлбэржүүлэх, сахал засах үйлчилгээнд тавих шаардлагыг тогтоох, Мэргэжлийн үсчдийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлаганд нийцсэн үйлчилгээг бий болгоход оршино.

2 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь толгойн үс, сахлыг төлбөртэй ба төлбөргүйгээр засах үсчний үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийн үйл ажиллагаанд хамаарна.

Иргэдийн ахуйн үйлчилгээнээс бусад цэргийн анги, нэгдсэн тогтолцоо бүхий байгууллага зэрэгт энэхүү стандарт хамаарахгүй.

3 Хэрэглэх хүрээ

3.1. Энэхүү стандартыг үс засах үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд үйлчилгээгээ чанаржуулахад анхаарч, эрхлэхээр зорьж буй этгээд нь цаашид төлөвлөж, мөрдлөг болгоно.

3.2. Үсчний үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэж буй, эрхлэхээр төлөвлөж байгаа этгээд нь нэгдсэн зохион байгуулалт бүхий бүртгэлтэй байж, тэдгээрийн үйл ажиллагааны ангилал олгох, шаардлага тавихад энэхүү стандартыг үндэслэл болгоно.

3.3 Үсчний үйл ажиллагааг явуулын буюу суурин бус үйлчилгээ үзүүлэхэд энэхүү стандартын холбогдох заалтуудыг хангана.

4 Норматив эшлэл

Дараах эшлэлийг энэхүү стандартын үзүүлэлт шаардлагад эшлэл болгон хэрэглэсэн. Эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн хэвлэлийг (түүний өөрчлөлтүүдийг оруулаад) хэрэглэнэ. Үүнд:

MNS 4968, Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага;

MNS 4990, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага;

MNS 4996, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага;

MNS 4244, Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;

MNS 5390, Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага.

5 Ангилал

5.1 Үсчний газарт буюу тухайн хүний нөөц, мэргэжлийн ур чадварт нийцүүлж тухайн үйлчилгээний газарт, мөн тухайн үсчинд олгож байгаа зэргийг:

- Дээд зэрэглэл,
- нэгдүгээр зэрэглэл,
- хоёрдугаар зэрэглэлийн гэж тус тус ангилана.

5.2 Ангилал зэрэглэлийг олгохдоо тодорхой шаардлага үзүүлэлтийг энэхүү стандартад нийцүүлэн салбарын асуудал эрхэлсэн төрийн ба төрийн бус байгууллагатай хамтран гаргаж, батламж, гэрчилгээ олгож болно.

6 Нэр томьёо, тодорхойлолт

6.1

Үсчний газар

Үйлчилгээний байгууллага нь бүртгэлтэй суурин газарт байх ба бусад ижил төстэй үйлчилгээ болох гоо сайхан, хумс засах үйлчилгээтэй хамт нэг дор байж болно.

6.2

Үс засах үйлчилгээ

Үйлчлүүлэгчийн хүсэлт, захиалгын үндсэн дээр үс засах мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ажилбарыг.

1-Р ТЭМДЭГЛЭЛ: Энэхүү стандартад “үс засах үйлчилгээ” эрхлэгчийг цаашид “үсчний газар” хэмээн хэмээн товчоор дурдана.

2-Р ТЭМДЭГЛЭЛ: үсчний газар нь гоо сайхны салон, хумс засах үйлчилгээ зэрэг хоорондоо харшлахгүй үйлчилгээтэй хамт нэг дор байж болно.

6.1 Үсчин

Үйлчлүүлэгчийн хүсэлт, захиалгын үндсэн дээр үс засах үйл ажиллагааны сургалтад хамрагдаж мэргэжсэн тухай сертификаттай иргэнийг.

ТЭМДЭГЛЭЛ: Үсчин нь хуйхны бүтцийг онош тогтоох эрхгүй, зөвхөн эмч, мэргэжлийн үсчний оношын дагуу арчлах, үйлчлэх эрхтэй байна

6.2 Мэргэжлийн үсчин

Үс засах үйлчилгээний багц сургалтад хамрагдан мэргэжсэн диплом, үнэлэхтэй иргэнийг.

ТЭМДЭГЛЭЛ: Мэргэжлийн үсчин, үс, хуйхны бүтцийг оношлох, арчлах, эмчлэх эрхтэй байна.

7 Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

7.1. Үсчний газар нь Монгол улсад бүртгэлтэй, эрх зүйн чадамжтай бөгөөд энэхүү стандартын шаардлагыг хангаж ажиллах чадвартай аж ахуйн нэгж байна.

7.1 Үйлчилгээний газар нь үсчний үйлчилгээ үзүүлэгч этгээдийн өөрийн эзэмшил буюу өмч биш бол түрээсийн буюу холбогдох гэрээг талууд энэхүү стандартын шаардлагуудыг тусган байгуулсан байна.

7.2. Үйлчилгээний дотоод журам, мэргэжлийн байгууллагаас баталсан технологийн заавар, үнийн тариф зэргийг үйлчлүүлэгч танилцаж болохоор ил газарт байршуулна.

7.3. Гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээний төрөл, түүнийг гүйцэтгэх огноо, цаг зэргийг багтаасан захиалгын хуудас, урьдчилгаа ба хийж гүйцэтгэсэн төлбөрийн тасалбар зэрэг тооцооны хуудсыг хэрэглэгчийн хүсэлтээр олгоно.

7.4 Үйлчлүүлэгчийн хүсэлтээр үс арчилгаанд хэрэглэсэн бүтээгдэхүүний нэр хийсэн үйлчилгээ зэргийг тодорхой дурдсан тодорхойлолтыг олгоно.

7.5 Үйлчилгээний байгууллага нь эрх бүхий байгууллагаар баталгаажсан, үсчний зориулалтын мэргэжлийн бүтээгдэхүүн шаардлага хангасан тохиолдолд үйлчилгээнд хэрэглэнэ:

а) үндэсний болон олон улсын стандартын шаардлагыг хангаж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор нөлөөгүй бүтээгдэхүүн болох тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, баталгаатай байх

б) бүтээгдэхүүн нь Монгол улс дахь албан ёсны төлөөлөх эрх бүхий байгууллагаас нийлүүлсэн байх

с) бүтээгдэхүүнийг хэрэглэх заавар, технологийн талаар сургалтад хамрагдсаныг баталгаажуулсан байх

7.6 Энэхүү стандартын А хавсралтын үзүүлэлт шаардлагыг хангасан байдлаар тогтоосон үйлчилгээний зэрэглэлтэй байна.

7.7. Үйлчилгээний газар нь өөрийн үйл ажиллагааны онцлог шинж, энэхүү стандартад нийцүүлэн дотоод журамтай байна.

7.8 Үсчний үйлчилгээнд ашиглаж буй багаж, хэрэгсэл нь хэрэглэх нөхцөл, шаардлагад нийцсэн ариутгал, халдваргүйжүүлэлтийг эрүүл ахуйн байгууллагаас гаргасан норм, дүрэм, зөвлөмжийн дагуу хийж байх.

8 Үйлчилгээний байгууллагад тавих нийтлэг шаардлага

8.1. Үйлчилгээний барилга байгууламж нь Монгол Улсын холбогдох “Барилгын норм ба дүрэм”-д заасан шаардлагыг хангасан эрх бүхий байгууллагаас баталсан зураг төслийн дагуу баригдсан зориулалтын буюу үйлчилгээний шаардлага хангахуйц өрөө, тасалгаатай байх бөгөөд энэхүү стандарт шаардлагыг цаашдын төлөвлөлтөд хангахыг зорино.

8.2. Үйлчилгээг дараах байршилд явуулахыг хориглоно:

- а) барилга байгууламжийн зоорийн давхар, агуулахад,
- б) байгалийн гэрэлтүүлэг тусахгүй, агаарын сэлгэх урсгалгүй байгууламжид,
- с) хүнс, хоол үйлдвэрлэл ба үйлчилгээ явуулж буй эзэмшил талбайд байрших болон давхцах эсвэл тэдгээрийн дээд давхарт байрших.

8.3. Үйлчилгээний байгууллага нь хаяг, үйлчилгээний цагийн хуваарь, үйлчилгээний үнийн жагсаалт, дотоод журам болон ажиллагсадын мэдээллийг үйлчлүүлэгчид харагдахуйц газарт байрлуулсан байна.

8.4. Үсчний газрын үйлчилгээний танхимд тавих шаардлага:

- нэг үсчин 4м.кв-аас багагүй талбайд ажиллана.
- Хүлээлгийн суудал нь үсчний суудлаас 2 метрээс багагүй зайтай байна,
- үсчин хоорондын зай нь үйлчлүүлэгчийн суух сандлын захын ирмэгээс хэмжээ авснаар хамгийн багадаа 1.8 метрээс багагүй байна,
- үйлчлүүлэгчийн суух сандал нь хананаас 0.7 метрээс багагүй хөндий зайтай байна.

8.6. Үйлчлүүлэгч нь гадуур хувцасаа тайлж өлгөх өлгүүртэй байна.

8.7. Үйлчилгээний газрын өрөө, тасалгааны ариутгал, хортон шавьжийн устгалыг эрүүл ахуйн байгууллагаас гаргасан норм, дүрэм, зөвлөмжийн дагуу мэргэжлийн байгууллагаар тодорхой давтамжтайгаар хийлгэнэ.

8.8. Үйлчилгээний байгууллагад анхны тусламж үзүүлэх шаардлага хангахуйц эмийн сантай байна.

8.9. Үйлчилгээний газрын хогийг битүү саванд битүүмжилж тодорхой хугацаанд зайлуулна.

8.10. Үйлчилгээний байгууллага нь үйлчлүүлэгчдэд зориулан мэргэжлийн бүтээгдэхүүн, багаж хэрэгсэл, барааны худалдаагаар үйлчилж болно.

8.11 Үйлчилгээний байгууллага нь өөрийн орчин тойронд хамаарах эдэлбэр буюу ноогдох газрынхаа орчны тохижилт, зүлэгжүүлэлт, ногоон байгууламж зэргийг байгаль орчин, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлж, болзошгүй аливаа эрсдэлт нөхцөл гарахаас урьдчилан сэргийлж, арга хэмжээг авсан байна.

8.12 Худалдааны төвд байх үсчний үйлчилгээний танхим нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан ханаар тусгаарлагдсан байх ба байгалийн гэрэлтүүлэг үзэх, салхивч бүхий цонхтой газарт байрлана.

8.13 Үйлчилгээний байгууллагын үсчин гоо сайхан, маникюр, педикюр нь нэг танхимд үйлчилгээ явуулах тохиолдолд тусгаарлалт хийн үйл ажиллагаа явуулж болно.

8.14 Долоо хоногт 1-ээс доошгүй удаа бүх өрөө, тасалгаануудад их цэвэрлэгээ хийнэ. Их цэвэрлэгээний үеэр хана, шал, хаалга, тавилга хэрэгслийг халдваргүйжлийн бодис бүхий уусмалаар ариутгаж цэвэрлэнэ.

8.15 Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авах, салбарын мэдээллийн баазыг үүсгэх, үнэлгээ хийх, шинжлэх ухааны ололт, амжилт, салбарын үр дүнг хуваалцах нэгдсэн зохион байгуулалтад орж, хамтарч ажиллахыг зорихыг эрмэлзэнэ.

9. Хүний нөөцийн хөгжилд тавих шаардлага

9.1. Үйлчилгээний байгууллагад ажиллагсад нь тухайн чиглэлээр мэргэшсэн, мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байна.

9.2. Ажиллагсад нь жилд нэгээс доошгүй удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна.

9.3. Үйлчилгээний ажиллагсад нь үйлчилгээний онцлогт тохирсон өөрийн нэр бүхий энгэрийн тэмдэг, хөдөлмөр хамгааллын хувцастай байна.

9.4. Үсчин нь А.3 хавсралтад дурдсан ажлын багаж хэрэгслэлээр хангагдсан байна.

9.5. Үйлчилгээний байгууллага нь ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана.

9.6. Үйлчилгээний байгууллага нь жилд нэг удаа ажилтнуудаа хөтөлбөрийн дагуу дараах сургалтад хамруулна. Үүнд:

- Мэргэжлийн ур чадварыг сайжруулах,
- хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй халваргүйжүүлэлт,
- Үйлчилгээний соёл, ёс зүй, харилцааны ур чадвар, хандлага

9.7. Үсчин нь байнга өөрийгөө хөгжүүлж ур чадвараа ахиулах үүднээс 2 жилд 1 удаа уралдаан тэмцээнд оролцох, жилд 2-оос доошгүй удаа сургалт семинарт хамрагдан (оноо цуглуулах) мэргэжлийн зэргээ ахиулах Үүнд:

- мэргэжлийн шинэ дэвшилтэт техник технологийн,
- бүтээгдэхүүний,
- Мэргэжлийн ур чадварын,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн,
- Харилцаа, хандлага, ёс зүй, үйлчилгээний соёл гэх мэт.

9.8. Үсчин нь тухайн байгууллагын хөдөлмөрийн гэрээ, дотоод журмыг мөрдөж ажиллана.

9.9. Хөдөлмөрийн гэрээний дагуу арга хэмжээ авах ба тохиролцоонд хүрээгүй тохиолдолд зөрчлийн тухай хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

9.10. Үсчин нь тухайн байгууллагын хөгжил дэвшилд өөрийн хувь нэмрээ оруулж шинэ санааг үйлчилгээнд нэвтрүүлэх, санаачлах

А. хавсралт (норматив) шинэчилсэн

Зэрэглэл		Дээд зэрэглэл	I зэрэглэл	II зэрэглэл		
Гадаад орчин	Хаяг	Эмблем бүхий гэрэлтүүлэг	+	+	-	
		Энгийн	-	-	+	
		Ажиллах цагийн хуваарь	+	+	+	
	Үүдний хэсэг	Довжоо, тавцанг хальтраа, гулгаанаас хамгаалсан	+	+	+	
		Машины зогсоол	+	+/-	-	
		Хогийн сав /ангилаан ялгах/	+	+	+	
		Хамгаалалт, дохиоллын хэрэгсэл	+	+	+/-	
Дотоод зохион байгуулалт	Хүлээлгийн өрөө	Хаалганы халаагуур /калорифер/	+/-	+/-	+/-	
		Гутал цэвэрлэгч дэвсгэр	+	+	+	
		Телефон утас	+	+	+	
		Зөөлөн тавилга	+	+	+/-	
		Сандал	+	+	+	
		Ширээ		+	+/-	
		Телевизор	+	+	+/-	
		Хөгжим	+	+	+/-	
		Хогийн сав /ангилаан ялгах/	+	+	+	
		Хувцасны өлгүүр	+	+	+	
		Ариун цэврийн өрөө	+	+	+/-	
		Үүнд:	Гар хатаагч / Гар арчих цаас	+	+	+/-
			Саван, ариутгагч	+	+	+
	Төрөлжсөн худалдааны лангуу	+	+/-	+/-		
	Мэдээлэл, сурталчилгааны материал	Зэрэглэлийн гэрчилгээ	+	+	+	
		Үйлчилгээний дүрэм, журам	+	+	+	
		Технологийн горим ²	+	+	+	
		Үнийн жагсаалт	+	+	+	
		Үс засалтын загваруудын цомог	+	+	+	
		Холбогдох сэтгүүл, сонин	+	+	+	
Багаж, бүтээгдэхүүний сурталчилгаа		+	+	+		
Мэргэжлийн зөвлөмж	+	+	+			

Дотоод зохион байгуулалт	Үйлчилгээний танхим	Төхижолт	Үс засах тасалгаа, танхим	+	+	+	
			Толь (80x120 см буюу түүнээс дээш)	+	+	+	
			Багаж хэрэгслэл, бодисуудыг байрлуулах (Ханын шүүгээ, Тавиур, Тэргэнцэр бусад)	+	+	+	
			Үсчний зориулалтын сандал	+	+	+	
			Будгийн зориулалтын өрөө, хэсэг	+	+/-	+/-	
			Халаалт	Төвийн төвлөрсөн	+	+	+/-
				Ердийн	-	-	+/-
			Усан хангамж	Төвийн төвлөрсөн	+	+	+/-
				Зөөврийн	-	-	+/-
			Агааржуулагч	Ердийн	+	+	+
				Автомат	+	+/-	+/-
				Салхивч	+	+	+
			Гэрэлтүүлэг	Байгалийн	+	+	+
	Зохиомол	+		+	+		
	Толины	+/-		+/-	+		
	Шал	Хулдаас		+/-	+/-	+/-	
		Паркет		+/-	+/-	+/-	
		Зориулалтын чулуун хавтанцар		+/-	+/-	+/-	
		Мод		+/-	+/-	+/-	
		Плита		+/-	+/-	+/-	
Гантиг		+/-	+/-	-			
Хивс, хивсэнцэр, нийлэг материал		-	-	-			
Бусад	Ахуйн хангамжийн өрөө		+	+/-	-		
	Ажилчдын өрөө	Ажилчдын хувцасны хэсэг	+	+	+/-		
		Ажилчдын ариун цэврийн өрөө	+	+/-	+/-		
		Ажилчдад зориулсан шүршүүр	+/-	+/-	+/-		
		Ажилчдын амралтын өрөө, хэсэг	+	+/-	+/-		
Төрөлжсөн агуулах, шүүгээ		+	+/-	+/-			
Ариутгал, хатаалтын хэсэг, өрөө		+	+/-	+/-			

А.2. Хүний нөөцийн хөгжил

Зэрэглэл		Дээд зэрэглэл	I зэрэглэл	II зэрэглэл
Үсчин	Мастер буюу 6-р түвшин	Нийт үсчдийн 20%-аас дээш	+/-	+/-
	1-р зэргийн буюу 5-р түвшин	Нийт үсчдийн 40%-аас дээш	Нийт үсчдийн 50%-аас дээш	+/-
	2-р зэргийн буюу 4-р түвшин	+/-	Нийт үсчдийн 30%-аас дээш	+/-
	3-р зэргийн 3-р түвшин	+/-	+/-	+/-
	1, 2-р түвшин, дагалдагч	+/-	+/-	+/-
Менежер	Үйлчилгээний зохион байгуулагч	+	+/-	+/-
	Бусад ажилтан	+	+/-	+/-

А.3. Багаж хэрэгслэл, материал болон ажилчдын хувцас

Зэрэглэл		Дээд	I түвшин	II түвшин	
Нийтийн	Кварцийн аппарат /тасалгааны ариутгалын/	+	+	+	
	Үс оношлогооны аппарат	+	+	+	
	Үсний уурын аппарат	+	+	-	
	Ариутгалын аппарат (багаж)	+	+	+	
	Угаалгын машин	+	+	+	
	Компьютер	+	+/-	+/-	
Үсчний нэг суудалд хэрэглэх	Хамгаалалтын нөмрөг	том	2 ба түүнээс дээш		
		жижиг	10 ба түүнээс дээш		
	Сальфеток		Нэг удаагийн		
	Хөвөн даавуун алчуур (50x40см ба 50x90)		15 ба түүнээс дээш		
	Сам	Тайралтын	3 ба түүнээс дээш		
		Нарийн хуваарилалтын	2 ба түүнээс дээш		
		Хэлбэр оруулах (төрөл бүрийн)	3 ба түүнээс дээш		
		Иллэг, массажны сам	2 ба түүнээс дээш		
	Хайч	Шулуун	2 ба түүнээс дээш		
		Шингэлгээний	1 ба түүнээс дээш		
		Үс буржийлгах (цахилгаан)	1 ба түүнээс дээш		
	Цахилгаан машин		1-2	1-2	1
	Цахилгаан сэнс		1 ба түүнээс дээш		
Хамгаалалттай		1 ба түүнээс дээш			

	Хутга	Хамгаалалтгүй	1 ба түүнээс дээш		
	Үсний индүү		1 ба түүнээс дээш		
	Дамар /бигуд/	100-150 ширхэг	+	+	+
		50-60 ширхэг	+	+	+
Үс будалт, хими	Химийн буржийлгын аппликатор		+	+	+
	Хэмжүүрийн сав		1 ба түүнээс дээш		
	Бодис түрхэх хэрэгсэл (порлон)		2 ба түүнээс дээш		
	Үс будалтын	Тугалган цаас	Хэмжээгүй		
		Зориулалтын нөмрөг	2 ба түүнээс дээш		
		Нэг удаагийн бээлий	Хэмжээгүй		
	Багс	Үс цэвэрлэх	1 ба түүнээс дээш		
		Будагны	3 ба түүнээс дээш		
		Сахлын	1 ба түүнээс дээш		
	Будгийн аяга		3 ба түүнээс дээш		
	Шүршигч		1 ба түүнээс дээш		
	Хавчаар		10 ба түүнээс дээш		
	Хормогч (зориулалтын)		+	+	+
хэмжигч (жин)		+	+	+	
Ажилчидын хувцас	Ажилтнуудын ажил үүргийн хуваарь, ажиллах заавар		+	+	+
	Нэг өнгийн, нэг төрлийн, загвараар ижилсүүлсэн		+	+	-